



**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН
ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2027-2028 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ТАЛААРХ ТӨСВИЙН БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНААС ГАРСАН
САНАЛД ӨГСӨН ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН
ДҮГНЭЛТ**

УЛААНБААТАР ХОТ

2025 оны 10 дугаар сарын 24-ний өдөр

**“МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЭЛ, 2027-2028 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ТӨСВИЙН
БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН
ХУРАЛДААНААС ГАРСАН САНАЛД ӨГСӨН ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ
БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64.1.5-д “нэгдсэн хуралдаанаар гурав дахь хэлэлцүүлгийг явуулахад ... Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гарсан санал Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төсвийн тусгай шаардлагад нийцсэн эсэх талаар Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дүгнэлт гаргаж, нэгдсэн хуралдаанд танилцуулна. Төсвийн тусгай шаардлага хангагдаагүй нөхцөл үүссэн тохиолдолд тодорхой асуудлаар чиглэл өгч, хоёр дахь хэлэлцүүлгийг дахин явуулахаар Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодод төслийг буцааж болно” хэмээн заасны дагуу Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дүгнэлт гарган танилцуулж байна.

Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн хоёрдугаар хэлэлцүүлгийн явцад УИХ-ын нэгдсэн чуулганы 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар “... Төслийн 1 дүгээр зүйлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд дэх нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ 2026 онд 31,600.0 тэрбум төгрөг гэснийг 490.0 тэрбум төгрөгөөр, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ 2026 онд 32,980.0 тэрбум төгрөг гэснийг 490.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, үүнтэй уялдуулан холбогдох эдийн засгийн үндсэн үзүүлэлт болон харгалзах ДНБ-д эзлэх хувьд өөрчлөлт оруулах” тухай зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй холбоотой дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын тухайд:

1.1. **Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон байх.** Санал болгосон өөрчлөлт нь орлогын дүнг өсгөх тухай бөгөөд нэмэгдэл орлогын эх үүсвэрийг тодорхойлоогүй, төсвийн орлогыг тооцох аргачлалд шууд нөлөөлөхгүй байна.

1.2. **Нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ ДНБ-ий 30%-аас хэтрэхгүй байх.** Санал болгосон өөрчлөлтийн нэрлэсэн ДНБ-д үзүүлэх нөлөө нь (1) нэмэлт орлогыг хэрхэн бүрдүүлэх, (2) зарлагын нэмэгдлийг хэрхэн зарцуулах, (3) энэхүү бодлогын сонголт иргэд, аж ахуйн нэгжийн шийдвэр гаргалтад үзүүлэх орлогын болон орлуулалтын нөлөөнөөс шууд хамаарах бөгөөд татварын орлогыг өсгөх замаар төсвийн орлогыг нэмэгдүүлж, энэ хэмжээгээр урсгал зардалд зарцуулах тохиолдолд гурав дахь хүчин зүйлээс хамааран ДНБ-д нэгэн зэрэг эерэг болон сөрөг нөлөө үзүүлэхээр байна.

Хүснэгт 1. Микро түвшний нөлөө

Өөрчлөлт	Иргэд, ААН-д үзүүлэх орлогын нөлөө	Иргэд, ААН-д үзүүлэх орлуулалтын нөлөө
490.0 тэрбум төгрөгийг татвараар бүрдүүлэх	Татварын дараах орлого нь 490.0 тэрбум төгрөгөөр багасах учир алдагдсан орлогоо тодорхой хэмжээнд нөхөх үүднээс хөдөлмөрийн нийлүүлэлт, үйлдвэрлэлийг өсгөх шаардлагатай болно.	Татварын дараах орлого буурах учир хөдөлмөр нийлүүлэх, үйлдвэрлэл явуулах нь өмнөхөөс бага ашигтай болж нийлүүлэлт, үйлдвэрлэлийг багасгана.
Урсгал (цалингийн) зарлагыг 490.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх	-Цалингийн нэмэгдэлд хамрагдах иргэдийн хувьд орлого нь нэмэгдсэнээр хэрэглээ нь өсөх, зээлийн эргэн төлөлт болон хадгаламж өссөнөөр хөрөнгө оруулалт нэмэгдэнэ. -Нийт импорт болон эдийн засгийн нийт эрэлт нэмэгдэнэ.	Төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэнээр төрд ажиллах нь илүү ашигтай болж: -хөдөлмөрийн нийлүүлэлт нэмэгдэх; -үйлчилгээний бусад салбарт хөдөлмөрийн эрэлт, нийлүүлэлт буурах, (төрийн секторт шилжих) үзэгдэл гарна.

Дээрх микро түвшний нөлөө нь эдийн засгийн нийт эрэлт болон нийлүүлэлтэд дараах байдлаар нөлөөлөхөөр байна.

Хүснэгт 2. Макро түвшний (нийт эрэлт) үзүүлэх нөлөө

Өөрчлөлт	Иргэд, ААН-д үзүүлэх орлогын нөлөө	Иргэд, ААН-д үзүүлэх орлуулалтын нөлөө
Татварын орлогыг 490.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх	Шууд нөлөөгүй	Шууд нөлөөгүй
Урсгал (цалингийн) зарлагыг 490.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх	Нэмэгдүүлнэ	Шууд нөлөөгүй

Хүснэгт 3. Макро түвшний (нийт нийлүүлэлт) үзүүлэх нөлөө

Өөрчлөлт	Иргэд, ААН-д үзүүлэх орлогын нөлөө	Иргэд, ААН-д үзүүлэх орлуулалтын нөлөө
Татварын орлогыг 490.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх	Эерэг, гэхдээ бага нөлөөтэй	Сөрөг нөлөөтэй
Урсгал (цалингийн) зарлагыг 490.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх	Шууд нөлөөгүй	Шууд нөлөөгүй

Эндээс үзэхэд макро түвшинд эдийн засгийн нийт эрэлт өсөх, нийт нийлүүлэлт багасах буюу өөрчлөгдөхгүй учир бодит ДНБ бага зэрэг өсөх, үүн дээр хавсран эрэлтээс улбаалсан үнийн өсөлтөөр дамжин нэрлэсэн ДНБ өсөх, энэхүү өсөлтийг боломжит дүнгээр тооцоход 2026 онд төсөөлсөн 102.4 их наядаас 512 орчим тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна. Энэ тохиолдолд санал болгосон өөрчлөлт нэгдсэн төсвийн урсгал зардлын ДНБ-д эзлэх хувийг 24.8% болгож өсгөхөөр байгаа ч 30%-ийн хязгаарт багтаж байна.

1.3. Нэгдсэн төсвийн суурь тэнцэл ДНБ-ий 2% буюу түүнээс дээш ашигтай байх.

Тэнцвэржүүлсэн орлого болон төсвийн урсгал зардлыг ижил дүнгээр өсгөх нь зээлийн ашиглалтад нөлөөлөхгүй тохиолдолд суурь тэнцлийн дүнд нөлөө үзүүлэхгүй буюу суурь тэнцэл хуулийн төсөл дээрх 2.048 их наяд төгрөг хэвээр үлдэхээр байна. Харин нэрлэсэн ДНБ-ийг 512 орчим тэрбум төгрөгөөр өсгөх бөгөөд энэ тохиолдолд суурь тэнцлийн ДНБ-д эзлэх хувь 1.9% болж дор хаяж 2.0% буюу түүнээс дээш ашигтай байх шаардлага зөрчигдөхөөр байна.

1.4. Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл ДНБ-ий 60%-аас хэтрэхгүй байх. Санал болгосон өөрчлөлт Засгийн газрын өрийн үлдэгдэлд шууд нөлөөлөхөөргүй байна. Харин нэрлэсэн ДНБ-ийг бага зэрэг өсгөх бөгөөд тус харьцаа өргөн мэдүүлсэн төслийнхөөс илүү буурах буюу 60%-ийн хязгаар дотроо байна.

2. Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн төсөлд үзүүлэх нөлөөллийн тухайд

2.1. Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон байх. Төсвийн хүрээний мэдэгдэл дэх орлогын доод хэмжээг нэмэгдүүлснээр төсвийн төсөл нь төсвийн хүрээнд нийцтэй байх тухай Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 5.1.3 дахь заалтын дагуу 2026 онд нэгдсэн төсвийн орлогыг дор хаяж 490 тэрбум төгрөгөөр өсгөх шаардлагыг үүсгэж байна.

2.2. Нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ ДНБ-ий 30%-аас хэтрэхгүй байх. Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1.7-д “Улсын төсвийг хэлэлцэн батлахдаа төсвийн орлого, зарлагын бүтцийг өөрчилж болно. Ингэхдээ Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлж үл болно”, мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71.7.2 дахь заалтын дагуу УИХ төсвийн нийт зарлагыг нэмэгдүүлэх эрх зүйн боломжгүй. Иймээс Төсвийн хүрээний мэдэгдэл дэх зарлагын дээд хэмжээг 490.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн ч 2026 оны нэгдсэн төсвийн төсөлд тусгагдсан зарлагын хэмжээг өсгөх боломжгүй юм. Санал болгосон өөрчлөлтийн нэрлэсэн ДНБ-д үзүүлэх цэвэр нөлөөг баримжаалан тооцвол 2026 оны нэрлэсэн ДНБ хуулийн төсөлд тусгагдсан дүнгээс 307.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна. Энэ тохиолдолд санал болгосон өөрчлөлт нь нэгдсэн төсвийн урсгал зардлын ДНБ-д эзлэх хувийг 24.8% болгож, 30%-ийн дотор байх хязгаарт багтах хэвээр байна.

2.3. Нэгдсэн төсвийн суурь тэнцэл ДНБ-ий 2% буюу түүнээс дээш ашигтай байх. Санал болгосон өөрчлөлт нь 2026 оны нэгдсэн төсвийн хувьд тэнцвэржүүлсэн

орлогыг 490.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх, нийт зарлага, цэвэр зээлийн дүнг үл өөрчлөх, мөн дүнгээр гадаад зээлийн ашиглалт буурах, зарлагад гарах тус орон зайгаар урсгал зардлыг нэмэгдүүлснээр суурь зарлага мөн дүнгээр өсөх учир 2026 оны МУНТ-ийн төсөл дээрх суурь тэнцлийн нэрлэсэн дүнд өөрчлөлт гарахгүй, улмаар нэрлэсэн ДНБ-д гарах 307.2 тэрбум төгрөгийн өөрчлөлтөөс үүдэн суурь тэнцэл ДНБ-ий 1.9% хувийн ашигтай болж тусгай шаардлага зөрчигдөх нөхцөл үүсэхээр байна.

- 2.4. Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл ДНБ-ий 60%-аас хэтрэхгүй байх.** Төсвийн төсөл нь төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн байх тухай Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 5.1.3 дахь заалтын дагуу санал болгосон өөрчлөлт нь төсвийн орлогыг нэмэгдүүлж, харин УИХ төсвийн зарлагыг нэмэгдүүлэхгүй байх Үндсэн хуулийн 25.1.7 дахь заалтын дагуу төсвийн зарлагад өөрчлөлт гарахгүй тул гадаад зээлийн ашиглалт буурч, Засгийн газрын өрийн нийт үлдэгдэл ДНБ-ий 60% дотор хадгалагдахаар байна.

ДҮГНЭЛТ

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн зүгээс УИХ-ын нэгдсэн чуулганы 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар дэмжигдсэн зарчмын зөрүүтэй санал нь:

1. *Төсвийн хүрээний мэдэгдлийн хувьд:* ДНБ болон суурь тэнцлийн нэрлэсэн дүнд нөлөө үзүүлэхгүй боловч Төсвийн хүрээний мэдэгдэл дэх суурь тэнцэл ДНБ-ий 2% буюу түүнээс дээш хувийн ашигтай байх төсвийн тусгай шаардлагыг зөрчих;
2. *Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн төслийн хувьд:* ДНБ, төсвийн орлогод болон зарлагын бүтцэд үзүүлэх нөлөөнөөс үүдэн төсвийн төсөлд тусгагдсан суурь тэнцэл ДНБ-ий 2% буюу түүнээс дээш хувийн ашигтай байх төсвийн тусгай шаардлагыг мөн зөрчих;
3. Төсвийн хүрээний мэдэгдлийг дагуулан төсвийн зарлагыг өөрчилж болзошгүй байдал нь Монгол Улсын Үндсэн хуулийн 25-р зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасан заалттай зөрчилдөх нөхцөлүүдийг үүсгэхээр байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64.1.5-д заасны дагуу “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг дахин явуулахаар Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодод буцаах нь зүйтэй гэж Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дүгнэж байна.

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ
БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ